

8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

“ХУВИЛБАР-А”

Эхийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

УУРЫН ТЭРЭГНИЙ ГАРАЛ ИЙМ УЧИРТАЙ

Ширээн дээр байгаа данхнаас ямарч дуу аниргүй чимээгүй л байгаа биз. Тэгвэл түүнийг цахилгаан зуухан дээр тавибал хэсэг хугацааны дараа доторх ус нь бужигнаж буцалж байснаа даргилж эхэлмэгц данхны таг тачигнан дуугарч эхэлдэг. Энэ юунаас болж байна вэ? Буцалж байгаа уснаас уур гарч байгаагаас тэр. Уснаас гарсан тэр уур данханд багтахаа байж тагны нүх сүвээр гадагш гарах гэж дээш нь түлхэж байгаа юм.

Ингээд л данх” амь орж” дуугардаг юм. Гэхдээ усны уур юм чинь дорхноо л замхраад алга болно. Тэр “юу ч биш” гэж бодуузай. Үнэндээ тэр бол асар их хүч тэнхээтэй эд. Хэрвээ хэн нэгэн сониуч этгээд данхны тагийг битүүлж, цоргоны нүхийг бөглөж орхих юм бол усны уур хэмээгч тэр их хүчтэн данхыг ёстой нэг будаа болгож орхино. Иймийн учир эрт дээр цагаас хүн төрөлхтөн усны уурын энэ их хүч чадлыг анзаарч түүнийг нь өөртөө ашигтайгаар хэрэглэж уурын тэргийг зохион бүтээсэн юм шүү.

(“Танин мэдэхүй” сэтгүүлээс)

1. Үгийн утгыг тайлбарлаарай. (2 оноо)

Утгыг тайлбарлах үгс	Үгийн утгыг тайлбарла
данх	
уур	
таг	

2. Эхээс сонин содон дүрслэлийн жишээ олж тайлбарлаарай. (2 оноо)

.....

.....

.....

.....

.....

3. Эхээс учир шалтгааныг илэрхийлэх жишээг олж бичээрэй. (2 оноо)

Данхны таг тачигнан дуугардгийн учир шалтгаан	үр дагаврыг бичээрэй	эхээс тохирох жишээ бичиж холбон тайлбарлаарай

4. “Намар, хичээл ордог бүх багш нар ангийн сурагчдын нэрсийг журналд бичдэг.” гэсэн өгүүлбэрийн найруулгын алдааг олж, засаж бичээрэй. \2 оноо \

.....

5. Хүснэгтэд тохирох жишээ эхээс олж бичээд тайлбарлаарай. (2 оноо)

	Эхээс тохирох жишээ	Тайлбар

**8-р анги хариу, түлхүүр
“А” хувилбар**

1. Үгийн утгыг тайлбарлаарай. (2 оноо)
 - 3 үг зөв тайлбарласан бол-2 оноо
 - 2 үг зөв тайлбарласан бол- 1.5 оноо
 - 1 үг зөв тайлбарласан бол-1 оноо

Утгыг тайлбарлах үгс	Үгийн утгыг тайлбарла
данх	Цай хийх, агуулах төмөрлөг сав
уур	Ус хийгээд ихэнх нь уснаас бүрдсэн шингэн зүйлийг халаахад агаарт дэгдэн хий болох усыг уур гэнэ.
таг	Тогоо, данх зэрэг сав суулганы амыг хаах зүйл

2. Эхээс сонин содон дүрслэлийн жишээ олж тайлбарлаарай. (2 оноо)
Ингээд л данх” амь орж” дуугардаг юм. Гэхдээ усны уур юм чинь дорхноо л замхраад алга болно. Тэр “юу ч биш” гэж бодуузай.
-амь орж хэмээн тагны уурын нөлөөнд өргөгдөх хөдөлгөөнийг дүрсэлсэн.

3. Эхээс учир шалтгааныг илэрхийлэх жишээг олж бичээрэй. (2 оноо)

Данхны таг тачигнан дуугардгийн учир шалтгаан	үр дагаврыг бичээрэй
Данхыг цахилгаан зуухан дээр тавибал хэсэг хугацааны дараа доторх ус нь бужигнаж буцалж байснаа даргилж эхэлмэгц	Иймийн учир эрт дээр цагаас хүн төрөлхтөн усны уурын энэ их хүч чадлыг анзаарч түүнийг нь өөртөө ашигтайгаар хэрэглэж уурын тэргийг зохион бүтээсэн юм шүү.

- Данхны таг тачигнан дуугардгийн учир, үр дагавар, тохирох жишээг олсон бол- 2 оноо
 - Үр дагаврыг бичээгүй бол 1.5 оноо
 - Тохирох жишээг олоогүй бол-1 оноо
4. Өгүүлбэрийн дунд буй “бүх” хэмээх үгийг хасна. Үг илүүдсэн алдааг олсон бол-2 оноо
 5. Хүснэгтэд тохирох жишээ эхээс олж бичээд тайлбарлаарай. (2 оноо)

	эхээс тохирох жишээ	Тайлбар
дүрслэл	данх” амь орж”	амьдчилал
баримт	Ширээн дээр байгаа данхнаас ямарч дуу аниргүй чимээгүй л байгаа биз.	

6. өгүүллэгээс төрсөн мэдрэмж, сэтгэгдэл, сургамжит санаа, ухаарч ойлгосон зүйлээ өөрийн үгээр үнэлж дүгнэж 40-50 үгэнд тайлбарлан бичээрэй. (5 оноо)

мэдрэмж сэтгэгдэл:

сургамжит санаа:

ухаарч ойлгосон зүйл:

7. Үндэсний бичгээс кириллрүү буулгах- /5 оноо/

Хадан дээр өвс ургуулах нэг бэрх

Цасан дээр гал түлэх нэг бэрх

Эвэр дээр цас тогтох нэг бэрх

Нийт-20 оноо

Б хувилбар- хариу

1. Эртээ урьдын цагт зээр гэдэг будаа шиг буцалж байсан юм гэсэн, хайрхаан ! /2 оноо/
2. “Гэсэр”, “Жангар” шиг мартагдах вий дээ гэсэн санаа /2 оноо/
3. Зохиогчийн баярласан шалтгаан: Мэнэнгийн талд ооно шаргачин үй олноороо гүйдэг цаг үлгэр болсон мэт өнөө цагт хүмүүсийн буруутай үйлээс ооно шаргачин ховордож байгаа учир халиурсан өвсөн дороос гүйж харайж байхыг цөөн харж байгаа учир баярласан. /2оноо/
 - Шалтгааныг бүрэн гаргаж бичсэн бол-2 оноо
 - Шалтгааныг дөхүүлсэн бол-1.5
 - Дутуу бичсэн бол-1 оноо
4. Өгүүлбэрийн дунд буй “бүх” хэмээх үгийг хасна. Үг илүүдсэн алдааг олсон бол-2 оноо
Тайлбар: Багш нар гэдэг үг олон тоон дээр байгаа бөгөөд бүх гэдэг үг илүүдсэн алдаа Илүүц үгийг олж тайлбарласан бол 2 оноо
Аль нэгийг нь бичсэн бол 1 оноо
Огт бичээгүй бол 0 оноо
5. Эхээс учир шалтгааныг илэрхийлэх жишээг олж бичээрэй. (2 оноо)

“Алтан бэлзэг олох мэт баярлана” гэсний учир шалтгаан	Үр дагаврыг бичээрэй	эхээс тохирох жишээ бичиж холбон тайлбарлаарай
Мэнэнгийн халиурсан өвсөнд ооно шаргачин цөөн тохиолдолд харж байгаа учраас	Ооно шаргачин өнөө цагт маш ховордсон.	Салхин дундаа жаргаж яваа нь тэр юм болов уу? Жаргал гэхэд ч бас айдас нүүрлэсэн орчлонд сүүдрээсээ ч цочин бусгах нь адтай.

- Учир шалтгаан, үр дагавар, тохирох жишээг олсон бол- 2 оноо
 - Үр дагаврыг бичээгүй бол 1.5 оноо
 - Тохирох жишээг олоогүй бол-1 оноо
6. С Дуламын “Хүмүүн бичиг” шүлгийн дараах хэсгийн цэгийн оронд гүйцээж бичээрэй. /5оноо/
Тэнгэр газар хоёрыг учруулж
Намираа хур орох мэт
Тэнүүн уйтан хоёрыг учирлаж
Морин хуур дарах мэт
 7. Үндэсний бичгээс кириллрүү буулгах- /5 оноо/
Хадан дээр өвс ургуулах нэг бэрх
Цасан дээр гал түлэх нэг бэрх
Эвэр дээр цас тогтох нэг бэрх

Нийт-20 оноо